



**МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 07 сарын 05 өдөр


Дугаар А/427

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 07/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үндэсний их баяр наадам зохион байгуулахтай холбогдуулан төв цэнгэлдэх хүрээлэнд урсгал засвар хийхэд зориулан материалын зардал болох 19,446,848 төгрөгийг зарцуулсугай.
2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 19,446,848 төгрөг (арван есөн сая дөрвөн зуун дөчин зургаан мянга найман зуун дөчин найм)-ийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 5/07 дугаар тогтоолын 7 дугаар хавсралтын 3.1-д Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн өвөлжилтийн бэлтгэл хангах, болзошгүй эрсдэлийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Баярсүх) нарт зөвшөөрсүгэй.
3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Т.Дэлгэрсайхан)-д даалгасугай.



Б.ДҮГЭРЖАВ

8400 01 2195
Zah A/427 Kh